Сэлэнгэ аймаг
Ерөө сум

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 он

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.06.17

ТАВИН

Сэлэнгэ аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган орон нутагт хамаарал бүхий 4 бүлгийн 15 зорилтын 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хагас жилийн байдлаар **36** арга хэмжээ 100 хувь, 15 арга хэмжээ 90 хувь, 11 арга хэмжээ 70 хувь, 22 арга хэмжээ 50 хувь, 7 арга хэмжээ 30 хувь, 3 арга хэмжээ 0 хувьтай буюу дунджаар **75.1** хувийн гүйцэтгэлтэй биелсэн гэж үнэллээ.

Үүнд:

- "Бүсчилсэн хөгжлийн бодлого" **70** хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"
- "Хүний хөгжлийн бодлого" **75.5** хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"
- "Эдийн засгийн бодлого" **74.2** буюу "үр дүн хүлээгдэж байгаа"
- "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" **77.7** хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа" тус тус үнэлгээтэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2025 оны хагас жилийн байдлаар салбар бүрээр нь товч танилцуулбал:

**Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого:**

1.1 Бүсийн төрөлжсөн хөгжил: 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 70 хувь буюу дунджаар **70** хувь.,

**Хоёр. Хүний хөгжлийн бодлого:** 6 дэд бүлгийн 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 19 заалт нь 100 хувь, 10 заалт нь 90 хувь, 1 заалт нь 70 хувь, 7 заалт нь 50 хувь, 1 заалт нь 30 хувь, 1 заалт нь 0 буюу хэрэгжих хугацаа болоогүй байна. Үүнээс:

2.1 **Боловсрол**: 9 зорилтын 9 арга хэмжээний 5 заалт нь 100 хувь, 4 заалт нь 90 хувь буюу дунджаар 95.5 хувь.,

2.2 **Соёл урлаг, үндэсний өв залгамжлал** → 2.2 **Соёл урлаг, үндэсний өв заншил**: 7 зорилтын 10 арга хэмжээний 2 заалт нь 100 хувь, 4 заалт нь 90 хувь, 1 заалт нь 70 хувь, 2 заалт нь 50 хувь, 1 заалт нь 0 хувь буюу дунджаар 73 хувь.,

2.3 **Эрүүл мэнд**: 3 зорилтын 6 арга хэмжээний 3 заалт нь 100 хувь, 2 заалт нь 90 хувь, 1 заалт нь 30 хувь буюу дунджаар 85 хувь.,

2.4 **Биеийн тамир спорт**: 1 зорилтын 3 арга хэмжээний 3 заалт нь 50 хувь буюу дунджаар **50** хувь;

2.5 **Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:** 2 зорилтын **2** арга хэмжээний 2 заалт нь **50** хувь буюу дунджаар **50** хувь;

2.6 **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал** дэд бүлгийн 6 зорилтын 9 арга хэмжээ нь 100 хувь буюу дунджаар **100** хувь;

**Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт 75.5 хувийн биелэлттэй байна.**

**Гурав. Эдийн засгийн бодлого:** 5 дэд бүлгийн 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс **7** заалт нь 100 хувь, 4 заалт нь 90 хувь, 3 заалт нь 70 хувь, 10 заалт нь 50 хувь, 4 заалт нь 30 хувь, 2 заалт нь 0 буюу дунджаар **74.2** хувийн биелэлттэй байна. Үүнээс:

3.1 Хөрөнгө оруулалт: 3 зорилтын 4 арга хэмжээний 2 заалт нь 100 хувь, 1 заалт нь 70 хувь, 1 заалт нь 50 хувь буюу дунджаар 80 хувь.,

3.2 Дэд бүтэц: 1 зорилтын 1 арга хэмжээ нь 90 хувь.,

3.3 Хүнс хөдөө аж ахуй: 8 зорилтын 13 арга хэмжээний 2 заалт нь 70 хувь, 8 заалт нь 50 хувь, 3 заалт нь 30 хувь буюу дунджаар 48.4 хувь.,

3.4 Байгаль орчин, уул уурхай, ногоон хөгжил: 7 зорилтын 8 арга хэмжээний 4 заалт нь 100 хувь, 1 заалт нь 50 хувь, 1 заалт нь 30 хувь, 2 заалт нь 0 буюу дунджаар 60 хувь.,

3.5 Төсөв санхүүгийн бодлого: 2 зорилтын 4 арга хэмжээ нь 1 заалт нь 100 хувь, 3 заалт нь 90 хувь буюу дунджаар 92.5 хувь.,

**Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт 74.2 хувь байна.**

**Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого:** 3 дэд бүлгийн 23 арга хэмжээнээс 10 заалт нь 100 хувь, 1 заалт нь 90 хувь, 5 заалт нь 70 хувь, 5 заалт нь 50 хувь, 2 заалт нь 30 хувь буюу дунджаар **77.7** хувь;

4.1 Цахим засаглал: 4 зорилтын 5 арга хэмжээний 3 заалт нь 100 хувь, 1 заалт нь 90 хувь, 1 заалт нь 70 хувь буюу дунджаар 92 хувь.,

4.2 Төрийн албаны шинэтгэл: 5 зорилтын 9 арга хэмжээний 3 заалт нь 100 хувь, 5 заалт нь 50 хувь, 1 заалт нь 30 буюу дунджаар 64.4 хувь.,

4.4 Батлан хамгаалах: 3 зорилтын 7 арга хэмжээ нь 3 заалт нь 100 хувь, 2 заалт нь 50 хувь, 2 заалт нь 30 хувь буюу дунджаар 65.7 хувь.,

**Бүлгийн нийт зорилтын хэрэгжилт 77.7 хувь байна**.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

**/2025 оны хагас жилийн байдлаар/**

| Зорилт | Арга хэмжээний тоо | Үнэлгээ | | | | | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| **Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого:** | | | | | | | | |
| 1.1 Бүсийн төрөлжсөн хөгжил | 2 | - | - | 2 | - | - | - | 70% |
| **Хоёр. Хүний хөгжлийн бодлого:** | | | | | | | | |
| 2.1 Боловсрол | 9 | 5 | 4 | - | - | - | - | 95.5% |
| 2.2 Соёл, урлаг үндэсний өв уламжлал | 10 | 2 | 4 | 1 | 2 | - | 1 | 73% |
| 2.3 Эрүүл мэнд | 6 | 3 | 2 | - | - | 1 | - | 85% |
| 2.4 Биеийн тамир, спорт | 3 | - | - | - | 3 | - | - | 50% |
| 2.5 Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого | 2 | - | - | - | 2 | - | - | 50% |
| 2.6 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал | 9 | 9 | - | - | - | - | - | 100% |
| **Гурав. Эдийн засгийн бодлого** | | | | | | | | |
| 3.1 Хөрөнгө оруулалт | 4 | 2 | - | 1 | 1 | - | - | 80% |
| 3.2 Дэд бүтэц | 1 | - | 1 | - | - | - | - | 90% |
| 3.3 Хүнс, хөдөө аж ахуй | 13 | - | - | 2 | 8 | 3 | - | 48.4% |
| 3.4 Байгаль орчин, уул уурхай, ногоон хөгжил | 8 | 4 | - | - | 1 | 1 | 2 | 60% |
| 3.5 Төсөв, санхүүгийн бодлого | 4 | 1 | 3 | - | - | - | - | 92.5% |
| **Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого** | | | | | | | | |
| 4.1 Цахим засаглал | 4 | 3 | 1 | - | - | - | - | 92.5% |
| 4.2 Төрийн албаны шинэчлэл | 12 | 4 | - | 5 | 3 | - | - | 75% |
| 4.4 Батлан хамгаалах | 7 | 3 | - | - | 2 | 2 | - | 65.7% |
| **Нийт:** | 94 | 36 | 15 | 11 | 22 | 7 | 3 | **75.1%** |

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Дугаар | ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| **1.1 Бүсийн төрөлжсөн хөгжил** | | | | | | | | | | | | |
| **Төвийн бүс "Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс"** | | | | | | | | | | | | |
| 1 | АЗДҮАХ 1.1.4 | "Нээлттэй Сэлэнгэ" хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах | 2025 он | ЗДТГ | Орон нутгийн төсөв | | Нээлттэй Сэлэнгэ -2030 хөтөлбөрийг 15 хувьтай зохион байгуулсан. | 30 | - | - | Нээлттэй Сэлэнгэ хөтөлбөрийн хүрээнд:<br>-Ерөө суманд шилжин ирэхээр хүсэлт гаргасан насанд хүрсэн 17, 16-аас доош насны 2 нийт 19 иргэний нотлох баримтыг үндэслэн бүртгэж баталгаажуулалт хийсэн. Тухайлбал бусад нийслэл, аймгаас 12, аймаг дотор, сум, баг хооронд 5 иргэн шилжилт хөдөлгөөн хийсэн.<br>-Улаанбаатар хотоос шилжиж ирсэн 1 иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас "3D арьсан эдлэл" төсөлд хамруулж 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-Ерөө сумын түүхэн дурсгалт газруудыг цахим хуудсаар сурталчлан 1542 иргэний хандалт авсан байна.<br>-"БТЕГ" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд 45 | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | сая төгрөгөөр 23 өрхийн 25 оюутныг хамруулсан.<br>- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын танилцуулгыг цаасан болон цахим /Eruu.se.gov.mn/ -аар иргэдэд сурталчилж 18546 иргэний хандалт авсан байна.<br>-Тайлант хугацаанд Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоог Төрийн албаны зөвлөлд хүргүүлж нэр дэвшүүлэх тогтоолын дагуу 2 албан хаагчийг төрийн захиргааны албанд томилсон. Түүн дотроо нэг иргэн нь Улаанбаатар хотоос шилжиж ирсэн.<br>-Хагас жилийн байдлаар шинэ ажлын байр – 28, ажилд зуучлал-28, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг 20 иргэнд, суурь ур чадвар олгох сургалтыг 20 иргэнд, ажил хайгч иргэн 42, пропайлинг үйлчилгээнд 10 иргэн, мэргэжлээ хэрхэн сонгох тухай сургалтыг ахлах ангийн 2 бүлэгт, ажилгүйдлийн тэтгэмжид 10 иргэн хамрагдах хүсэлт гаргаж ижоб программд бүртгэгдсэн байна.<br>-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Тарьсан мод бүр ирээдүйн хөрөнгө” урианы дор ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуйн нэгж байгууллага 7 төрлийн гоёлын болон жимсний модны 397 ширхэг суулгацыг иргэд, албан байгууллагуудад нийлүүлэн ажиллалаа. Сумын хэмжээнд аж ахуйн нэгж, албан байгууллагууд 317 ширхэг, 90 өрх 450 ширхэг нийт 767 ширхэг гоёлын болон жимсний мод, бут сөөгийг тариалсан байна. Мөн ойн санг гэрээгээр эзэмшигч 14 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл 248,7 га талбайд 621750 ширхэг тарьц суулгацаар өөрийн хөрөнгийн ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 оны А/128 дугаар захирамж, сумын Засаг даргын 2025 оны А/84 дугаар захирамжийн дагуу төлөвлөгөө боловсруулж бүх нийтийн | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд нийт давхардсан тоогоор 670 иргэн, албан хаагчид хамрагдаж нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, албан байгууллага өөрсдийн эзэмшил газарт хог цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэн 50 тн энгийн хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан байна. Сумын хэмжээнд хагас жилийн байдлаар нийтийн эзэмшлийн зам талбайн 16 байршлын 165 тн хог хаягдлыг цэвэрлэж, Тавин, Буурагчин багийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 44 аж ахуйн нэгж байгууллага, 329 айл өрхийн 175 тн энгийн хог хаягдлыг цуглуулж сумын төвлөрсөн хогийн цэгт "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ хүргэж ажилласан. 2025 оны 04 дүгээр сарын 11-13 ны өдрүүдэд БТЕГол ххк-тай хамтран сумын төвийн төвлөрсөн хогийн цэг орчмын 2.25 га газрын тархсан хог хаягдлыг түрж, бөөгнүүлж, булшлах ажлыг хийж гүйцэтгэлээ. | |
| 2 | АЗДҮАХ 1.1.14 | Ерөө- Бугантын чиглэлийн 47.5 км авто замын ашиглалтад оруулах | 2025 он | ЗДТГ | Улсын төсөв | 5,900.0 | - | Тухайн оны санхүүжилтээр хэрэгжих авто замын ажлыг 100 хувь дуусгана. | - | - | Ерөө- Бугантын чиглэлийн 27.5 км авто замын ажлын захиалагчаар Зам тээврийн яамнаас 2024 онд худалдан авах ажиллагаа зарлаж Эрдэнэт суварга" ХХК шалгарч 2025 оны ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70 |
| **Хоёр.Хүний хөгжлийн бодлого:** | | | | | | | | | | | | |
| **2.1 Боловсрол:** | | | | | | | | | | | | |
| 3 | АЗДҮАХ 2.1.1.1 | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн хувилбарт сургалтад хамруулах. | 2025 он | СӨБ | Улсын төсөв | - | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжих боломжоор хангаж ажилладаг. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулна. | - | - | **Цэцэрлэг** ялгаатай хэрэгцээтэй 6 хүүхдийг цэцэрлэгт ердийн сургалтаар хамруулсан. Хүүхдийн гэр бүлд түшиглэн явуулын багш ажиллуулж 50 хүүхдийг хувилбарт сургалтад хамруулан зуны гэр цэцэрлэгийг 2 бүлэг ажиллуулж байна. **Ерөнхий боловсролын сургуулийн** хэмжээнд оношлогдсон хөгжлийн бэрхшээлтэй 14 суралцагч байна. Үүнээс сонсголын бэрхшээлтэй 2, оюун ухааны бэрхшээлтэй 5, өвчний оноштой 7 | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | суралцагч, хавсарсан оноштой 1 суралцагч байна.12 суралцагч танхимаар, 2 сурагч зайнаас суралцах хувилбарыг сонгон боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдан суралцаж байна.<br>Ялгаатай хэрэгцээтэй, хэл яриа, танин мэдэхүй, нийгэмшихүй, хөдөлгөөний хоцрогдолтой 5 сурагчийн эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан өөртөө үйлчлэх энгийн чадвар, хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол, нийгэмшил, бие бялдар, хөдөлгөөн гэсэн хөгжлийн 4 айгаар урт болон богино хугацааны зорилго тавин 6 багш ажиллаж байна.<br>Хичээлээс гадуурх 7 үйл ажиллагаанд 7 сурагч, урлагийн наадмын 2-3 төрөлд 9 сурагч тус тус хамрагдан оролцсон. Мөн дугуйлан, секц, клубт 6 суралцагч хамрагдан хөгжиж байгаа бөгөөд 2 сурагч "Эсгий урлал наамал" төрлөөр бүтээлийн үзэсгэлэнгээ гаргаж Ерөө бүсийн хүүхдийн урлагийн наадамд эсгий урлалын бүтээлээр оролцож алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлэн хөгжиж байна. Монголын хүүхдийн спортын VIII наадамд 10б ангийн сурагч М.Мөнхцэцэг 100м гүйлтийн төрлөөр мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | |
| 4 | АЗДҮАХ 2.1.1.4 | Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг нэмэгдүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулах | 2025 он | ЕБС, СӨБ | - | - | Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээ 72,1% | Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг зохион байгуулж, үнэлгээг 77.25-д хүргэх | - | - | **Ерөө:** 2024-2025 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр 87 суралцагч элсэн суралцаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-д үндэслэнэ.<br>ЕБС-ийн 1–р ангид шинээр элсэн суралцаж буй 6 настай хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай байдал, СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, суралцахуйн чиглэл бүрээр эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлыг илрүүлэх, цаашид суралцахад нь дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулахад | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | суурь мэдээллээр хангах зорилгоор үнэлгээг хийсэн бөгөөд 1-р ангийн 87 сурагч хамрагдсан. Үнэлгээний гүйцэтгэл 73% байна.<br>**Бугант:**<br>**ЕБС:** Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд хамрагдах сурагчдын тоо 70, Үүнээс ХБ хүүхэд 1, СӨБ хамрагдсан хүүхдийн тоо 64, СӨБ хамрагдаагүй 5 сурагч хамрагдсан.<br>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний даалгавар:<br>1. Нийгэмшихүй - ойлгох , хэрэглэх түвшин<br>2. Бие бялдар - эрүүл мэнд, хөдөлгөөн<br>3. Танин мэдэхүй,-математик энгийн төсөөлөл<br>4. Танин мэдэхүй - байгаль, нийгмийн орчин<br>5. Танин мэдэхүй - хэл яриа<br>6. Танин мэдэхүй- дүрлэх урлаг<br>7. Танин мэдэхүй – хөгжим<br>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 74 %-тай үнэлэгдсэн<br>**Цэцэрлэг**: Хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийж 199 хүүхэд хамрагдахаас 189 хүүхэд хамрагдаж 180 хүүхэд буюу 95 хувь нь хангалттай үнэлэгдсэн. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр 90.2 хувьтай үнэлэгдсэн болно. | |
| 5 | | Сургалтын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулах | | | - | - | Гүйцэтгэлийн үнэлгээ 75,1% | Сургалтын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээг 90,8 хувь, сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээг 78,6 хувьд хүргэх | | | **Цэцэрлэг:** Цэцэрлэгийн Боловсролын Ерөнхий газраас хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр Улсын хэмжээнд 3 дугаар түвшинд үнэлэгдсэн. Сургалтын стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалтаар хүүхдийг хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулан 92 хувьд үнэлэгдсэн.<br>**ЕБС:** 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 78,7 хувь буюу өмнөх оноос 5,6 хувиар өссөн тус зорилгыг хангасан боловч эрэмбийн хувь буурч V түвшинд үнэлэгдсэн. Байгууллагын үнэлгээг дээшлүүлэх зорилгоор 6 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | шалгуурын дагуу менежментийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. | |
| 6 | | Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн гүйцэтгэлийн үнэлгээг нэмэгдүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулах | | | - | - | Гүйцэтгэлийн үнэлгээ 75,1% | Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн гүйцэтгэлийн үнэлгээг 91,6 хувь, сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг 78.1 хувьд хүргэх | | | **Ерөө:**<br>**Цэцэрлэг:** Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлж сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 90.1%, хүүхдийн хөгжил хамгаалал 90.9%, Хүний нөөцийн бодлого багш ажилчид 95.6%, сургалтын орчин бүрдүүлэлт 95.4% гүйцэтгэлийн дундаж 92% өмнөх оноос 16.1 хувиар ахисан.<br>**ЕБС:** 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд дунд ангийн 22 багш, бага ангийн 15 багш нийт 37 багш үнэлгээнд бүртгүүлснээс бага ангийн 3 багш үнэлгээнд ороогүй бөгөөд дунд ангийн 1 багш шилжиж явсан. 33 багшаас 21 багш буюу 63,6% нь гүйцэтгэлийн үнэлгээнд тэнцсэн. 4 шалгуураар харьцуулахад<br>□ Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт,ахиц үр дүн 2,03% ахисан<br>□ Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн 8,13% ахисан<br>□ Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн 6,88% ахисан<br>□ Байгууллага, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, үр дүн – 3,6% буурсан<br>Нэгдсэн дүнгээр 3% ахисан үзүүлэлттэй дүгнэгдсэн.<br>**Бугант**:<br>**ЕБС:** Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 28 багш хамрагдсан. Үүнээс<br>• 2-р түвшинд 4 багш<br>• 3-р түвшинд 8 багш<br>• 4-р түвшинд 8 багш үнэлэгдсэн.<br>Өмнөх жилийн амжилтыг нэмэгдүүлэх үүднээс багш нар мэргэжлийн хичээлээр агуулгын хоцрогдол арилгах давтлага хуваарийн дагуу хийсэн.<br>**Цэцэрлэг**: Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 7 багш хамрагдсанаас: | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 1-р түвшинд -3 багш<br>2-р түвшинд – 3 багш<br>3-р түвшинд 1 багш тус тус үнэлэгдсэн.<br>2025 оны гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 9 багш хамрагдсан | |
| 7 | | Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн математикийн хичээлийг финляндийн “Эдүтэн” цахим систем ашиглан зохион байгуулах | 2025 он | ЕБС | Улсын төсөв | | EDUTEN хөтөлбөрт бага ангийн 173 сурагч хамрагдсан. | EDUTEN хөтөлбөрт бага ангийн 446 сурагч 100% хамруулах | | | Цахим -1 танхимд хичээлийн хуваарийн дагуу EDUTEN хөтөлбөрийг 1-5-р ангийн 736 сурагчдыг хамруулан цахим систем ашиглан хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд сурагчдын идэвх оролцоо нэмэгдэж, даалгаврын гүйцэтгэл ахисан. EDUTEN хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх сургалтыг бага ангийн эцэг эхчүүдэд зохион байгуулсан. | 100 |
| 8 | АЗДҮАХ 2.1.1.5 | Ерөнхий боловсролын сургуулийн 3-6 дугаар ангийн суралцагчдад цахим технологид суурилсан “Pearson” хөтөлбөрийн хэрэгжүүлэх | | | | | PEARSON хөтөлбөрийг бага ангийн 4,5-р ангийн сурагчдад хэрэгжүүлсэн. | PEARSON хөтөлбөрийг 5-7-р ангийн сурагчдад хэрэгжүүлэх. | | | Цахим технологид суурилсан “Pearson” хөтөлбөрийг хэрэгжүүлэх танхим бэлтгэсэн. Цахим технологид суурилсан “Pearson” хөтөлбөрийг 5-р ангийн 151 сурагчдыг хамруулан хичээллэсэн. 6-р ангид 141 сурагч, 7-р ангийн 128 сурагч тус хөтөлбөрт хамрагдан 100 хувь цахим орчинд хичээллэж байна.<br>Бугант ЕБС-ийн захиргаа нь БЕГ болон Боловсролын яамнаас хэрэгжүүлж буй Эдүтэн, Персон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор нөхөн хангалтын зардлаараа 48 ширхэг таблетуудыг нэг дор цэнэглэх хүчин чадалтай "Charging box"- нийт 3500000 төгрөгөөр авч сурагчдын сурах таатай орчныг бүдүүлсэн. | 100 |
| 9 | АЗДҮАХ 2.1.1.11 | Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг олгох сургалт зохион байгуулах | 2025 он | ЕБС | Улсын төсөв | | 3 удаагийн сургалт зохион байгуулсан. | Сургалтын чиглэл, хамрах хүрээг нэмэгдүүлэх | | | **Ерөө:** “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр“-ийн хүрээнд 5 удаагийн сургалтад 317 сурагчийг хамруулан ажилласан ба нөлөөллийн ажлын чиглэлээр 2 удаагийн үйл ажиллагаанд 60 сурагч оролцсон.<br>**Бугант:** Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Бугант НТСН-ийн багш Х. Эрдэнэсолонго, Бугант ЕБС-ийн нийгмийн ажилтан И.Саякат хамтран<br>1. “Хүссэн мэргэжлээрээ сурахын тулд ямар хичээлээр шалгалт өгөх вэ?” | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн мэргэжлийн ангид орохын тулд өгөх хичээлүүд мөн тухайн сургуулийн шалгуур, онцлог" сэдвээр цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. Цахим сургалтад Сэлэнгэ аймгийн нийт 265 суралцагч 21 багш хамрагдсан. Манай сургуулийн 10-12-р ангийн 71 сурагч 3 багш хамрагдсан.<br>3. НТСН-ийн багш Х.Эрдэнэсолонго бие даалтын 7 хоногоор " АМЧБО" сургалт зохион байгуулсан. Сургалтад 10 дугаар ангийн 26 сурагч, 12 дугаар ангийн 20 сурагч хамрагдсан.<br>Сургалтын менежер О.Мөнхсаруул нь<br>• 10-12-р ангийн сурагчдад "Гадаад, дотоодын тэтгэлгийн боломжууд" Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга О.Сийлэгмаагийн мэдээлэл.<br>• 12-р ангийн сурагчдад " ЭШ өгөхөд сурагчдын гаргадаг алдаа"<br>• 9-12-р ангийн сурагчдад "Хичээлээ орхихгүйгээр олимпиад, ЭШ-нд бэлтгэх зөвлөгөө"<br>• 10,11, 12-р ангийн сурагчдад, эцэг эх, асран хамгаалагч нарт " Монгол хэл бичгийн шалгалтад хэрхэн бэлтгэх, оролцохдоо сурагчид юуг анхаарах хэрэгтэй вэ?"<br>• 9,10,11,12-р ангийн сурагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод бэлтгэх"<br>• Мэргэжил сонголтод гэр бүлийн үүрэг, хэрхэн хамтрах вэ?" эцэг эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан сургалтад 11-12-р ангийн 34 эцэг эх хамрагдсан. | |
| 10 | АЗДҮАХ 2.1.1.17 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйчдийг ажиллуулах | 2025 он | ЕБС | Орон нутгийн төсөв | | Сэтгэл зүйчтэй, хоол зүйчгүй | Сэтгэл зүйчтэй ажиллах гэрээг сунгах, хоол зүйчтэй болох | | | Мэргэшсэн сэтгэл зүйчтэй 2 жилийн гэрээ байгуулан ажилласан бөгөөд одоогоор гэрээний хугацааг дахин сунгаж ажиллахаар болсон. Сэтгэл зүйчийн өрөөний спорт заалны талын ханаы дуу чимээг багасгаж тусгаарлах зорилгоор | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | нэмэлт ханыг захиргаа аж ахуйн ажилтнууд хийж гүйцэтгэсэн. | |
| 11 | АЗДҮАХ 2.1.1.9 | "Сургалтын байгууллага- Тоног төхөөрөмж 2" арга хэмжээг боловсруулан батлуулан, хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 2025 он | ЕБС | Орон нутгийн төсөв | | 2024 онд хэрэгжүүлж Ерөө цэцэрлэг тоног төхөөрөмжтэй болсон. | Бугант цэцэрлэгт хэрэгжүүлнэ. | | | **Бугант ЕБС:** Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15 ширхэг иж бүрэн суурин компьютер, ширээ 47,224,050 төгрөг хүлээлгэн өгсөн.<br>- БЕГ-ын хөрөнгө оруулалтаар 75 инчийн зурагт – 2,486,345 төгрөг<br>- БЕГ-ын хөрөнгө оруулалтаар chromebook- 13 ширхэг 12,350,000 төгрөг<br>- Дезерет Олон улсын Энэрэлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар 11 ширхэг Chromebook 17,401,780 төгрөг<br>- Сургуулийн нөхөн хангалтын зардлаар – Кабинет №2 Цахим анги байгуулсан. | 90 |
| **2.2 Соёл урлаг, үндэсний өв заншил:** | | | | | | | | | | | | |
| 12 | АЗДҮАХ 2.2.1.9 | Соёл урлагийн салбарын хүний нөөцийн чадавхжуулах олон талт сургалт зохион байгуулах | 2025 он | Соёл төв | Улсын төсөв | | 2 албан хаагчийг их дээд сургуульд суралцах боломжоор хангаж ажилласан. | Мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна. | | | 1. 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсад-1, аймагтаа-4, сумандаа 5, цахимаар- 9, байгууллагын дотоод сургалт-3 нийт 22 удаагийн сургалт семинарт хөгжмийн багш, номын санч, Соёлын төвийн дарга, бүжгийн багш, ОНСТанхимын ажилтан нар хамрагдлаа.<br><br>2. Соёлын төвийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах зорилгоор СУИС-ийн харъяа Соёлын дээд сургуулийн "**Номын сангийн**" эчнээ ангид номын санч Ц.Болортуяа, "**Соёлын өв, музей судлал**"-ын эчнээ ангид ОНСТАжилтан Б.Сэрчмаа нар нь тус тус эчнээгээр суралцахад нь суралцах хугацааны цалинг 100% олгон ажиллаж байна. | 90 |
| 13 | АЗДҮАХ 2.2.1.10 | Угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | Угийн бичиг хөтлөх 2 видео контент болон цахим сургалт сурталчилгаа | Угийн бичиг хөтлөх талаар 2-3 арга хэмжээ зохион байгуулах. | | | Угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлэх ажлын хүрээнд 2 арга хэмжээ зохион байгуулж 36 иргэнийг хамруулсан.<br>1. "Угийн бичгээ хөтөлж – Ураг удмаа мэдэцгээе" аяны хүрээнд угийн бичгийн ач холбогдол, цахим | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | г зохион байгуулсан. | | | | орчинд хөтлөлт хийх талаар мэдээлэл бүхий сургалтыг төр, төсвийн 4 байгууллагын 26 албан хаагчдад хийсэн.<br>2. Мөн "Угийн бичгээ хөтлөж, ураг удмаа мэдэцгээе" эссэ бичлэгийн уралдаанд нийт 10 иргэн оролцсон.<br>Угийн бичгийн 3 удаагийн сургалтад 2 алба хаагч хамрагдлаа. Үүнд:<br>1.Сэлэнгэ аймагт болсон "Ураг удмаа мэдэж- угийн бичиг хөтөлцгөөе" сургагч багш бэлтгэх Сертификаттай сургалт,<br>2.СУИС-ийн Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан "Угийн бичгийг цахим хэлбэрээр хөтлөх нь" сургалт<br>3."Угийн бичиг" цахим сургалтуудад тус тус хамрагдсан. | |
| 14 | АЗДҮАХ 2.2.1.1 | "Бид Сэлэнгийн үр сад" хүүхдийн урлагийн их наадмыг зохион байгуулах | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | - | Бид Сэлэнгийн үр сад урлагийн их наадамд оролцох. | | | Хугацаа болоогүй байна. | 0 |
| 15 | | Монгол үндэстний өв соёл, уламжлал, аймаг орон нутгийн онцлогийг шингээсэн олон талт урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах | 2025 он | Соёл төв | Улс, Орон нутгийн төсөв | | 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан. | - | | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 86 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 7879 иргэнийг хамруулан ажиллалаа. | 90 |
| 16 | АЗДҮАХ 2.2.1.2 | Соёл урлагийн байгууллагуудын морин хуурын хангалтыг нэмэгдүүлэх | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | 26 морин хуур хөгжимтэй. | - | | | Соёлын төв нь 26 морин хуур хөгжимтэй. Одоогоор морин хуур шинээр нэмэгдээгүй байна. | 50 |
| 17 | | Шавь сургалтыг зохион байгуулах | | | | | Морин хуурын дугуйланд 30 хүүхэд хамрагдсан. | Жилд 20-30 хүүхдийг тогтмол хамруулна. | | | Соёлын төвийн дэргэдэх морин хуурын дугуйланд 15 хүүхэд суралцаж 7 хоногийн 5 өдөр 2 цагаар суралцаж байна. Эхний хагас жилийн байдлаар 9 арга хэмжээний тоглолтод оролцож 1215 хүнд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | АЗДҮАХ 2.2.1.3 | Орон нутгийн түүх соёл, онцлог шинжийг агуулсан утга зохиол, ном хэвлэл, тайз дэлгэцийн уран бүтээл болон хүүхдэд зориулсан соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ. | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | 3 арга хэмжээг зохион байгуулсан. | Үзвэр үйлчилгээг иргэдэд тогтмол үзүүлнэ. | | | -Тайз дэлгэцийн уран бүтээл болох Хөтөл соёлын ордны "Чингисийн бага нас" дуулалт жүжгийг хүлээн авч үйлчилсэн. Үзэгчдийн тоо 291.<br>-Хүүхдэд зориулсан соёлын 11 арга хэмжээнд давхардсан тоогоо 302 хүүхэд хамрагдсан. | 90 |
| 19 | АЗДҮАХ 2.2.1.4 | "Хүн бүр ном уншицгаая аян"-ыг өрнүүлэх | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | Цахимаар зүйр цэцэн үг-235, Оньсого-112, Үлгэр-119, Тууж-64, Өгүүллэг-45 сурталчлан ажилласан байна. | Сургалт сурталчилгааг тухай бүрт нь зохион байгуулж, сурталчилна. | | | "**Хүн бүр ном уншицгаая аян**"-ны хүрээнд **"ОЮУНЛАГ ИРГЭН"** уралдааныг 1,2-р багийн иргэдийн дунд зохион байгуулж 8 иргэн оролцсон. Тэмцээний зардалд 120,000 төгрөг зарцуулсан.<br>**Бугант:** "Хүн бүр ном уншицгаая" аяныг зохион байгуулж 68 уншигч хамрагдаж 214 ном уншлагад гарсан байна | 90 |
| 20 | | Номын сангуудын тоног төхөөрөмжийг стандартын дагуу хангаж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | - | Номын сангийн тоног төхөөрөмжийг стандартын дагуу шинэчлэх | | | Номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нөхцөл байдлын судалгаа хийснээр стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангагдах шаардлагатай байна.<br>Номын сангаас эхний хагас жилийн байдлаар номын сангийн үйлчилгээг гэрээр, танхимаар, явуулын болон нүүдлийн хэлбэрээр нийт 383 иргэнд 780 ширхэг номоор хүрч үйлчилсэн. | 50 |
| 21 | АЗДҮАХ 2.2.1.5 | Хүүхэд гэр бүлд чиглэсэн "Гэр бүл-Соёлын анхдагч орчин" нөлөөллийн арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулах | 2025 он | Соёл төв | Орон нутгийн төсөв | | Арга хэмжээ зохион байгуулах | Олон талт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | | | Гэр бүлд чиглэсэн 2 арга хэмжээнд нийт 19 хүн оролцсон. Үүнд: Шинээр гэр бүл болсон 2 хосын гэрлэлтийн батлахыг гардуулах ёслолын ажиллагаа, "Супер Аав, Ээж, Би" хөгжөөнт тэмцээн явууллаа.<br>Хүүхэд рүү чиглэсэн 11 арга хэмжээнд 302 хүүхэд хамрагдлаа. Үүнд: "Үйлчин охин", "Манлай хөвгүүн","Өнгөт бөмбөлөг" "Алтан хонх", "Эстрадын бяцхан дуучин", "Open mic", "Үлгэрээр хүмүүжье", "Номын тухай хэн сайн эшлэл бичих вэ", " Монгол ардын ерөөл магтаал" видео бичлэгийн уралдаан, | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | "Бид бужигчин", "Эхлэл ба төгсгөл" тоглолт зэрэг болно. | |
| 2.3 Эрүүл мэнд: | | | | | | | | | | | | |
| 22 | | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт | | | | | 35-77 % | Эрт илрүүлгийг 80 хувьд хүргэх | | | Артерийн даралт , Чихрийн шижин 2863 хүн хамрагдахаас 634 буюу 22,1 хувь<br>Элэгний эрт илрүүлэг 760 буюу 26,5 хувь, Хөх умайн эрт илрүүлэг 25,7 хувьтай байна | 30 % |
| 23 | АЗДҮАХ 2.3.1.1 | Эрүүл шүд арга хэмжээний /2024-2027/ тухайн оны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт | 2025 он | ЭМТ | Орон нутгийн төсөв | | - | Эрүүл шүд арга хэмжээг зохион байгуулна. | | | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол, "Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай, Эрүүл мэндийн сайд, Боловсрол ,Шинжлэх Ухааны Сайдын хамтарсан 2024 оны 01 дүгээр сарын 19 ны өдрийн А/27, А/25 дугаар тушаалыг хэрэгжүүлэх "24/3 Шүдээ зөв угаа -2025 " үндэсний аяны хүрээнд 9-12 насны 349 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаас 338 хүүхэд буюу 96 хувийг хамруулахад эрүүл 108 буюу 31%, шүдний өвчлөлтэй 228 хүүхэд буюу 68%, 142 буюу 48 хүүхэд эмчлэгдсэн байна.<br>Боловсролын сайдын хамтарсан А/415, А/151 тоот тушаалын дагуу хийгдэж буй "Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 86 хүүхэд хамрагдсан<br>85 хүүхдээс шүдний өвчлөлтэй 73 хувь 100 хувь фтор түрхэж эрүүлжүүлсэн. | 100 |
| 24 | АЗДҮАХ 2.3.1.4 | Томуугийн дархлаажуулалтад сургууль цэцэрлэгийн зорилтод насны хүүхдүүдийг хамруулах | 2025 он | ЭМТ | Улс, Орон нутгийн төсөв | | - | Томуугүйн дархлаажуулалт ад сургууль, цэцэрлэгийн зорилтод насны хүүхдүүдийг хамруулах | | | Товлолт дархлаажуулалт:<br>✓ Халдварт саа -тарьдаг -3<br>✓ Халдварт саа -уудаг -37<br>✓ Тавт вакцин -36<br>✓ ПЭВ – вакцин-49<br>✓ УГУ-вакцин -38<br>✓ А гепатит -31<br>✓ БЦЖ-0<br>✓ В гепатит -0<br>✓ ХПВ – вакцин -46<br>Тархвар судлалын дархлаажуулалт:<br>✓ Хачиг вакцин 172<br>✓ Галзуугийн вакцин 10<br>✓ Томуугийн вакцин 165<br>✓ УУ вакцин -21 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ✓ В гепатит сайн дур -20<br>Ковид вакцин -20 | |
| 25 | | Хүний папиллома вирусын эсрэг товлолын дархлаажуулалтад зорилтод насны хүүхдүүдийг хамруулах | 2025 он | ЭМТ | Улс, Орон нутгийн төсөв | | - | Дархлаажуулалтад 100 хувь хамруулна. | | | Хүний папиллома вирусийн эсрэг товлолын дархлаажуулалтад зорилтот бүлгийн 11 настай хамрагдвал зохих 149 хүүхдээс 144 хүүхдийг 100 хувь хамруулна. | 100 |
| 26 | АЗДҮАХ 2.3.1.5 | Уушигны эмгэг илрүүлэх үзлэгт зорилтот бүгийн хүн амын хамрагдалт | 2025 он | ЭМТ | Улс, Орон нутгийн төсөв | | 90% | “Сүрьеэгүй Сэлэнгэ-2” арга хэмжээг хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хамруулах илрүүлэлтийн хувийг зорилтот түвшинд хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцох | | | Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтан “Тиймээ, бид сүрьеэг устгаж чадна, амлалтаа хэрэгжүүлье, хөрөнгө оруулъя, үйлчилгээ хүргэе” урианы дор тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд нийт 3 байгууллагын 887 иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн 76 сурагчдыг хамруулан сургалт хийж, 18 хүүхэд оролцсон цахим бичлэгийн уралдаан, 2 иргэн дэмжлэгт туслалцаа үзүүлэн ажилласан.<br>Эрүүл мэндийн яам, Глобал сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Монгол Улсын ДОХ, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээний үндсэний тогтолцоог бэхжүүлэх нь” хөтөлбөр буюу “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сумын эрүүл мэндийн төвийн түвшинд бэхжүүлэх нь” дэд хөтөлбөр, аймгийн “Сүрьеэгүй Сэлэнгэ” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран “Хаалганаас-Хаалганд” сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг Сэлэнгэ аймгийн Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ий Баянгол уурхайн ажилтнуудын дунд амжилттай зохион байгууллаа.<br>Сүрьеэгийн эрт илрүүлгийн баг 2025 оны 05 дугаар сарын 03-04, 17–18-ны өдрүүдэд “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ий Баянгол уурхайд хоёр удаа ажиллаж, хиймэл оюун ухаанд суурилсан зөөврийн дижитал рентген төхөөрөмж ашиглан нийт 1500 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | гаруй уурхайн албан хаагч, ажилчдыг үзлэг, оношилгоонд хамрууллаа. | |
| 27 | | Далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан үр дүнгийн хэрэгжилт | | | | | - | Далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцох | | | Урьдчилан сэргийлэх үзлэгээр уушигны эмгэг өөрчлөлттэй 49 иргэнийг шинжилгээ оношилгоонд хамруулахад далд хэлбэрийн сүрьеэ илрээгүй. | 100 |
| **2.4 Биеийн таимр спорт:** | | | | | | | | | | | | |
| 28 | АЗДҮАХ 2.4.1.1<br>2.4.1.4 | Нийтийг хамарсан биеийн тамир спортын уламжлалт арга хэмжээг зохион байгуулах | 2025 он | Спор цогцо лбор | Улсын төсөв | | | Нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээнд иргэдийг хамруулах. | | | Монгол улсын шигшээ багийн тамирчин волейболын мастер Ш.Жамьяншарав агсны нэрэмжит тэгсөгчдийн дунд зохион байгуулагддаг волейболын тэмцээн 2025 оны 06 дугаар сарын 07,08-ний өдрүүдэд зохион байгуулагдан нийт 39 багийн 312 тэгсөгчид амжилттай оролцсон байна.<br>Нийтийн биеийн тамир спортоор хичээллэгсдэд зориулан 1,2 багийн иргэдийн дунд волейболын тэмцээн мөн сагсан бөмбөг ширээний теннис ,дартсын тэмцээнүүдийг зохион байгуулсан нийт давхацсан тоогоор 70гаруй иргэн спортын 5 төрлөөр оролцсон байна . Мөн идэвхтэй амьдрал урианы дор ахмадууд Ерөө сумын ахмадын холбоотой хамран өглөө бүр дасгал хөдөлгөөн алхалт хийж байна .Үүнд 25 иргэд ахмадууд хамрагдаад байна . | 50 |
| 29 | | Албан байгууллага, аж ахуйн нэгж төрийн бус байгууллагуудтай хамтран биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулах | 2025 он | Спор цогцо лбор | Улсын төсөв | | Жил бүр өвөл цагийн соёл хүмүүжлийн арга хэмжээг зохион байгуулдаг. | Биеийн тамирыг дэмжсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна. | | | Жил бүр албан байгууллага, ААН, иргэдийн дунд "Захирагчийн цом" 6 төрөлт тэмцээн зохион байгуулагддаг.<br>Аж ахуй нэгж болон албан байгууллагуудад спортын 5 төрөлт тэмцээн ,өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан. Аж ахуйн нэгж албан байгууллага иргэдийн дундах тэмцээнд давхардсан тоогоор 70гаруй иргэд оролцсон байна. Мөн жил бүр сурагчдын лиг сагсан бөмбөгийн тэмцээнийг БТЕГ ХХК-тай хамран 3 дахь жилдээ амжилттай зохиогдоод байна | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг стандарт үзүүлэлтээр жил бүр 4, 10 сард тогтмол авч хэвшүүлэн судалгааг хийж хамрах хүрээг нэмэгдүүлэх | 2025 он | Спор цогцо лбор | Улсын төсөв | | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд 250 иргэнийг хамруулсан. | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд 350 иргэнийг хамруулна. | | | 2025 оны хагас жилийн байдлаар 3-5 насны сорилд 45 хүүхэд, өсвөр насны хүүхэд 200, идэрчүүд насанд хүрэгчид 180, нийт сорилд хамрагдсан иргэн 425 байна . | 50 |
| **2.5 Хүүхэд залуучууд, гэр бүл:** | | | | | | | | | | | | |
| 31 | АЗДҮАХ 2.5.1.2 | Гэр бүлийн гишүүн бүрт сэтгэл зүйн зөвлөгөөг тасралтгүй хүргүүлэн, гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 2025 он | ЗДТГ | Улсын төсөв | | - | Олон талт нөлөөллийн ажил арга хэмжээг зохион байгуулна. | | | "Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдөр"-ийг тохиолдуулан Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүүхдийг зэргээр хүмүүжүүлэх аргуудын талаар 25 иргэнд сургалт зохион байгуулж, цахимаар 5 төрлийн мэдээлэл хүргэж 452 иргэний хандалт авсан. | 50 |
| 32 | АЗДҮАХ 2.5.1.7 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжиж, хөгжлийн бэрхшээлийн талаарх иргэд олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах | 2025 он | ЗДТГ | Орон нутгийн төсөв | | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжин ажиллах | | | **Бугант:** Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/364 тоот албан бичиг, Сэлэнгэ аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны "Хүсэлт гаргах тухай" албан бичгийн дагуу Бугант тосгонд 04 дүгээр сарын 02-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уулзалт зохион байгуулан ажиллалаа.<br>Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны 2025 онд хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу сумдын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа, хэрэгжиж буй хууль тогтоомж, шинээр гарсан төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл хүргэж иргэд болон хөгжлийн ялгаатай хүүхдүүдийн эцэг эхтэй уулзалт зохион байгуулсан. Холбооноос 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон хууль дүрэм, журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэж, орон нутгийн удирдлага, иргэдтэй уулзаж санал бодлоо солилцсон. Мөн Бугант тосгоны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар холбооны | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | тэргүүн Б.Оюунгэрэл 2022-2024 оны тайлан, тулгамдаж буй асуудал, цаашид хэрхэн ажиллах тухай илтгэл тавьж, туршлага судаллаа. | |
| **2.6 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал** | | | | | | | | | | | | |
| 33 | АЗДҮАХ 2.6.1.1 | Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд ажилгүй иргэн, залуучуудад шинэ ажлын байрыг бий болгох | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв, хандив | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог санхүүгийн дэмжлэгт 4 иргэн хамрагдаж 9 ажлын байр бий болсон. | Ахмад настан-2, ХБИ -1, Иргэн -1, | 31.0 | 48.0 | 2025 оны хагас жилийн байдлаар малжуулах санхүүгийн дэмжлэгт Н.Нямсүрэн хамрагдаж 8,0 сая төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт Л.Дунгаамаа сүү цагаан идээ боловсруулах төслөөр хамрагдаж 10,0 сая төгрөг, Т.Энхтуяа "Эрүүл хүнс" төслөөр 10,0 сая, иргэний ажлын байрыг дэмжих төсөлд Б.Энх-Амгалан 3D арьсан эдлэл урлах төслөөр 10.0 сая төгрөг, Ш.Эрдэнэбаяр Кола кебаб түргэн хоолны төслөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч нийт 4 иргэнд 48,000,000 сая төгрөгийн санхүүжилт олгож 7 шинэ ажлын байр бий болсон байна. | 100 |
| 34 | АЗДҮАХ 2.6.1.2 | Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв, хандив | | 2024 онд 425 иргэнийг мэдээллийн санд бүртгэсэн. | ШАБ, Зуучлал, Ажил хайгч, АМЧБО, Пропайлинг үйлчилгээ, | 0 | 0 | **Ерөө:** Хагас жилийн байдлаар шинэ ажлын байр – 28, ажилд зуучлал-28, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг 20 иргэнд, суурь ур чадвар олгох сургалтыг 20 иргэнд, ажил хайгч иргэн 42, пропайлинг үйлчилгээнд 10 иргэн, мэргэжлээ хэрхэн сонгох тухай сургалтыг ахлах ангийн 2 бүлэгт, ажилгүйдлийн тэтгэмжид 10 иргэн хамрагдах хүсэлт гаргаж ижоб программд бүртгэгдсэн байна.<br>**Бугант:** Бугант тосгоны ажилгүй , ажил олоход хүндрэлтэй 17 иргэнийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад түр болон үндсэн ажилтнаар зуучлан ажилласан байна. | 100 |
| 35 | АЗДҮАХ 2.6.1.3 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв /job center/-ийг орон нутагт нээж ажиллуулах | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв, хандив | | Сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ejob | Ажил хайгч, Ажил олгогч, зуучлал | - | - | Сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ejob программыг хөтлөн хөдөлмөрийн харилцааны үйлчилгээг тогтмол бүртгэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | программыг хөтлөн хөдөлмөрийн харилцааны үйлчилгээг тогтмол бүртгэн ажиллаж байна. | | | | | |
| 36 | | Ажил зуучлагдсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ | | | | | 2024 оны хагас жилийн байдлаар 44 ажилд зуучлал ижоб програмд бүртгэсэн байна. | Ажилд зуучлагдсан иргэдийн тоо | | | Хагас жилийн байдлаар уул уурхайн 3 аж ахуйн нэгж байгууллагад 12 ажлын байр, төр, төсвийн 4 байгууллагад 10 ажлын байр, санхүүгийн дэмжлэгийн үр дүнд 6 ажлын байр бий болж зуучлалыг Ejob программд тухай бүр бүртгэж мэдээлсэн байна. | 100 |
| 37 | АЗДҮАХ 2.6.1.5 | Зорилтот эмзэг бүлэгт чиглэсэн үйлчилгээ үзүүлэх | 2025 он | ЗДТГ | Орон нутгийн төсөв | | Малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт олгосон. | Зорилтот бүлгийн иргэдийг олон талт үйлчилгээнд хамруулах. | | 50,0 | Малжуулах санхүүгийн дэмжлэгт 2-р багийн иргэн Н.Нямсүрэнгийн төсөл дэмжигдэн 8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдан 4 тугалтай үнээ, 2 охин бяруу, нийт 10 толгой эм үхэр худалдан авч малаа өсгөн, өрхийн амьжиргаагаа нэмэгдүүллээ.<br>Аж ахуй эрхлэлтийн зээлийн өмнөх сургалтад хөгжлийн бэрхшээлттэй 2 иргэн хамрагдаж бизнес санаагаа хэрхэн төсөл болгож бичих талаар мэдлэгтэй болсон.<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2.682.4 мянган төгрөг, тэднийг асрагч 20 иргэнд нийгмийн халамжийн сангаас 34.874.6 мянган төгрөгийн тэтгэмж олголоо.<br>Мөн харилцаа холбооны хөнгөлөлтөд хамрагдсан 3 иргэнд 600.0 мянган төгрөг, хиймэл шүдний үнийн хөнгөлөлтөд 3 иргэнд 390.0 мянган төгрөг, нийт 6 иргэнд 990.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | АЗДҮАХ 2.6.2.1 | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид залуучуудын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв, хандив | | 6 | 12 | | | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 0-3 насны хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг/эх нийт 20 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулан хамрагдалтыг нэмэгдүүлсэн. | 100 |
| 39 | | Соён гэгээрүүлж сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | | | | | Соён гэгээрүүлж сурталчлах арга хэмжээг зохион байгуулдаг | Соён гэгээрүүлж сурталчлах арга хэмжээг зохион байгуулна | | | Ажил олгогч даатгуулагч болон 1,2-р багийн малчид иргэдэд танхимаар болон явуулын үйлчилгээгээр 1 удаа сургалт хийж давхардсан тоогоор нийт 797 гаруй иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. | 100 |
| 40 | АЗДҮАХ 2.6.2.2 | Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв, хандив | | - | 24 | | | Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 24 үйлчилгээ цахимжиж нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчид 100 цахимаар хүсэлтээ илгээж шийдвэрлүүлж байна. | 100 |
| 41 | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг барагдуулах | | | | | - | Тайлант хугацаанд өр авлага үүсгэхгүй байх. | | | **Ерөө:** Хуримтлагдсан өртэй ААНБ-уудын шимтгэлийн өр авлагыг барагдуулж мөн тайлант хугацаанд нэмж өр авлага үүсгэхгүй үүссэн шимтгэлийг сар бүр төлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.<br><br>**Бугант**: Өмнөх оны хуримтлагдсан өр авлагаас жилийн эцсийн байдлаар 8299,4 мян/төгрөгийг барагдуулж ажилласан. | 100 |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:** | | | | | | | | | | | | |
| **3.1 Хөрөнгө оруулалт:** | | | | | | | | | | | | |
| 42 | АЗДҮАХ 3.1.2 | Иргэдийн оролцоотойгоор хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах. | 2025 он | ЗДТГ | Улс, Орон нутгийн төсөв | | 2024 онд 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтууд хийгдсэн. | Хяналт тавьж ажиллах | | 9,6 тэрбум | Сумын ИТХ-ын даргын 2024.11.23-ны "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай" А/03 захирамжаар Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, Сумын төсвийн хөрөнгө оруулалт, Сумын Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт зэрэг 4 ажлын хэсэгт 2024 оны ажлыг шалгуулсан. | 100 |
| 43 | | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл хэрэгжилтийг хугацаанд нь мэдээллийн системд | | | | | ОНХС-ын цахим системд мэдээлэл оруулж хэвшсэн. | 13 тайланг хугацаанд нь шивэх | | 4,6 тэрмбум | Сумын ИТХ-ын 2023.12.20 өдрийн 4,618,829.9 төгрөгийн ОНХС-ын өртөгтэй 26 төсөл арга хэмжээг цахим системд 620 чиглэлийн 13 тайланг шивж оруулсан. Үнэлэх хугацаа болоогүй байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулж, урамшуулалд хамруулах | | | | | | | | | |
| 44 | АЗДҮАХ 3.1.4 | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар бүрэн зохион байгуулах | 2025 он | ЗДТГ | | | 2024 онд 9,3 тэрбум төгрөгийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтууд хийгдсэн. | Батлагдсан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх | | 11.7 тэрбум | Сумын ИТХ-ын 2024.12.30 өдрийн тогтоолоор 11,720,376.2 төгрөгийн 50 төсөл арга хэмжээг Засаг даргын төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Гэрээ байгуулсан 42 төсөл арга хэмжээ эрх олгосон 2, зарлагдаад үнэлгээний явцад 2 огт зарлагдаагүй 4 ажил байна. | 50 |
| 45 | АЗДҮАХ 3.1.8 | Ерөө суманд 400 суудалтай соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах | 2025 он | ЗДТГ | Улсын төсөв | 3,886.0 | Одоогийн соёлын төвийн барилга МХ ашиглаж болохгүй дүгнэлт гарсан | - | | 3,886,0 | Улсын төсвийн хөрөнгө оруулалттай Ерөө суманд 400 суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэгчээр Нано бриллиант ХХК шалгарч 2024-2025 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэлээр 2025 оны ажил 70 хувь байна | 70 |
| **3.2 Дэд бүтэц:** | | | | | | | | | | | |
| 46 | АЗДҮАХ 3.2.1 | "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө - 2040" ТЭЗҮ-г боловсруулж, хөрөнгийг шийдвэрлэх | 2025 он | ЗДТГ | | | 30 | 100 | | 198,0 | 2023 оны төсвийн жилд "Хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө" хийх худалдан авах ажиллагаанд "Ланд овнер" ХХК шалгарч 198 сая төгрөгөөр 90 хувь гүйцэтгэж байна. | 90 |
| **3.3 Хүнс, хөдөө аж ахуй:** | | | | | | | | | | | |
| 47 | АЗДҮАХ 3.3.2 | "Атар IV" аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, аймгийн газар тариалангийн нийт эргэлтийн талбайг нэмэгдүүлэх | 2025 он | ЗДТГ | | | Газар тариалангийн нийт эргэлтийн талбай 24103 га | Тариалангийн талбайн ангилал шилжүүлэхэд холбогдох материалыг бүртгэлжүүлэн ажиллах | | | Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд тариаланд шилжүүлэх боломжтой 253 байршил бүхий 2122,1 га талбайг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг хүргүүлэн ажиллаж байна.<br>Сумын хэмжээнд 18 ААН, 11 иргэн 12199,4 га талбайд буюу нийт эргэлтийн талбайн 50,6 хувьд тариалалт хийгээд байна.<br>✓ Улаан буудай – 8410,2 га талбайд<br>✓ Овьёос -51,2 га<br>✓ Ногоон тэжээл -140 га<br>✓ Тосны ургамал – 3276 га<br>✓ Эмийн ургамал – 322 га талбайд тус тус тариалаад байна. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
